



ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРҮҮА ХҮНС 1984
ОНООС ТАНЫ СОНГОЛТ

2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

www.talkh-chikher.com
info@talkh-chiker.mn



Агуулга

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

01

- Компанийн тухай
- Эрхэм зорилго, Үнэт зүйлс

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

02

- Зах зээлийн стратеги
- Брэнд хөгжүүлэлт
- Үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдал

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

03

- Хураангуй тойм

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

04

- Хүний нөөцийн бодлого
- Нийгмийн хариуцлага
- Амжилт
- 2023 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Эрүүл хүнс таны сонголт

“Талх Чихэр” ХК нь 1984 онд “Талх Чихрийн комбинат” нэртэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж, 1999 онд 100% хувьчлагдаж, 4000 гаруй хувьцаа эзэмшигчтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа Монголын топ 100 аж ахуй нэгжийн нэг.

Эрүүл хүнс Таны сонголт уриатай “Талх Чихэр” ХК өдгөө талх, талхан бүтээгдэхүүнийг 24 цаг тасралтгүй үйлдвэрлэх 6 шугам, нарийн боов үйлдвэрлэлийн 4 шугам, жигнэмэг, чихрийн шугам, бялуу, бэйкери төрлийн нандин бүтээгдэхүүн үйлдвэрлэх “Хотол” бялууны үйлдвэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэ хугацаанд бид АНУ, БНЧУ, БНСУ, ОХУ, БНХАУ, ХБАГ, Итали, Франц, Голланд, Испани, Финланд зэрэг улстай гадаад харилцаагаа тэлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тоног төхөөрөмж, урсгал шугамыг салбартаа анх удаа нэвтрүүлэн, үйл ажиллагаагаа улам өргөжүүлсээр байна



Эрхэм зорилго

Бид олон улсын чанарын стандартад нийцсэн дэвшилтэт технологиор бүтээгдэхүүнээ үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, хэрэглэгч харилцагчдынхаа сэтгэл ханамжинд үнэлэгдсэн хүнсний салбарын загвар компани байна.



Алсын хараа

Хувьсан өөрчлөгдөх хэрэглээний соёлыг тодорхойлон, стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийгэмд үнэ цэнэ бүтээгч, хүн төвтэй байгууллага байна.

Үнэт зүйлс

- Т** - Тэргүүн технологи
- А** - Аюулгүй бүтээгдэхүүн
- Ч** - Чадварлаг ажилтан
- И** - Итгэлцэл, түншлэл



Бизнесийн үйл ажиллагаа

Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага өөрчлөгдөж, шинэ хэрэглээ, соёл бий болж байгаа учраас бүтээгдэхүүний нэр төрөл нэмэх, бүтээгдэхүүний чанар стандартад анхаарах шаардлага байнга бий болдог. 2022 оны зорилтын хүрээнд бид зах зээлээ өргөжүүлэн, хөгжүүлэх стратегийг баримтлан, хэрэглэгч, харилцагчидтайгаа эргэх холбоог сайжруулан, судалгааны ажлыг тогтмол хийсээр ирсэн.

2022 онд шинэ брэнд бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ зориулан үйлдвэрлэн, хүргэж эхэлсэн. Хэрэглэгчдэд хэрэглээний шинэ соёл хэвшүүлэх, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, брэндийн онцлогт тохирсон маркетингийн стратегийг тодорхойлон, Сошиал болон Эвент маркетингийн стратегийг баримтлан ажилласан. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх байнгын сайжруулалтын ажлуудыг төлөвлөж ажиллаа.

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА СТРАТЕГИ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН СТРАТЕГИ

ИННОВАЦИЙН ХӨГЖИЛ
УДИРДЛАГЫН СТРАТЕГИ



ХЭРЭГЛЭГЧ БА МАРКЕТИНГИЙН СТРАТЕГИ



ЗАХ ЗЭЭЛИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ,
БРЭНДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Үйлдвэрлэлийн инновацыг тогтмол хийж, хүнсний аюулгүй байдлыг баримтлан, үйл ажиллагааны гинжин холбоог оновчтой байдлаар ажлуулахын тулд бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үйлдвэрлэлт, борлуулалт, түгээлт болон харилцагч нарт хяналт тавих бодлого баримтлан ажиллах

Бүтээгдэхүүн үйлдвэрлээд хэрэглэгчдийн гарт шууд хүргэх бус, дата мэдээлэл, ажиглалт судалгаан дээр тулгуурлан хэрэглэгчдийн чиг хандлагад тулгуурлан сэтгэл ханамжийг тэргүүнд тавин ажиллах

ORIGINAL TASTE

Khacan

ТАЛХНЫ ЗАХ ЗЭЭЛ

ТАЛХНЫ ЗАХ ЗЭЭЛД ЖИЖИГЛЭН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ӨРСӨЛДӨӨН ИХСЭЖ БАЙГАА БОЛОВЧ БИД ТЭРГҮҮЛЭХ БАЙР СУУРИА АЛДАХГҮЙ ХЭРЭГЛЭГЧИДИЙГ ХЭРЭГЛЭЭНИЙ СОЁЛД ЧИГЛҮҮЛЭН СУРГАЖ ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН САНАЛ БОЛГОН АЖИЛЛАЖ БАЙНА.

“ТАЛХ ЧИХЭР” ХК НЬ 44 НЭР ТӨРЛИЙН ТАЛХЫГ 12 БРЭНДИЙН НЭРИЙН ДООР ТАЛХ ҮЙЛДВЭРЛЭЖ БАЙНА.

ANYTIME
ANYWHERE
MAKE YOUR OWN



DÉLICE
PASTRY

НАРИЙН БООВНЫ ЗАХ ЗЭЭЛ

2022 ОНД ЖИЛД ДУНДЖААР 30576,5 ТН НАРИЙН БООВ ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ЖИЛ ИРЭХ ТУСАМ ЭНЭХҮҮ ТОО ӨСӨХ ХАНДЛАГАТАЙ БАЙНА. ЭНЭ НЬ ХЭРЭГЛЭЭНИЙ ЧИГ ХАНДЛАГА, СОЁЛ ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДӨЖ БАЙГААГ ХАРУУЛЖ БАЙНА.

ТИЙМЭЭС БИД ДАВХРААТ ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ШИНЭ БРЭНДИЙГ ЗАХ ЗЭЭЛД НЭВТРҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА. МӨН ЧАНАР, СТАНДАРТ, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ДЭЭД ЗЭРГЭЭР ХАНГАСАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЖ БУСАД ИЖИЛ ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ХИЙДЭГ ҮЙЛДВЭРЛЭГЧЭЭС ЯЛГАРАН АЖИЛЛАЖ БАЙНА.

“ТАЛХ ЧИХЭР” ХК НЬ 46 НЭР ТӨРЛИЙН НАРИЙН БООВЫГ 4 БРЭНДИЙН НЭРИЙН ДООР ЗАХ ЗЭЭЛД ХУДАЛДААЛЖ БАЙНА.

БЯЛУУ БОЛОН БЭЙКЕРИ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ

2022 ОНД БЯЛУУНЫ ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД БУУРСАН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ БОЛОВЧ МАРКЕТИНГ ИДЭВХЖҮҮЛЭЛТ ИЛҮҮ САЙЖИРСАН ОЛНЫГ ХАМАРДАГ БОЛСОН НЬ ҮЙЛДВЭРЛЭГЧ НАР МАСС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТОО ХЭМЖЭЭГ БУУРУУЛЖ ЗАХИАЛГЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ЧАНАР, ҮЗЭМЖ ДЭЭР АНХААРЧ АЖИЛЛАСАН НЬ ХАРАГДАЖ БАЙНА.

“ТАЛХ ЧИХЭР” ХК НЬ “ХОТОЛ” БРЭНДИЙН 62 НЭРИЙН БЭЙКЕРИ БҮТЭЭГДЭХҮҮН, 32 ГАРУЙ БЯЛУУ ҮЙЛДВЭРЛЭН ЗАХ ЗЭЭЛД ХУДАЛДААЛЖ БАЙНА.

DELICE PASTRY

Сэтгэл булаам амт



“DELICE PASTRY” БРЭНД

“Талх Чихэр” ХК 2018 оноос хойш Дэлхийд алдартай Круассан буюу давхраат төрлийн бүтээгдэхүүний шинэ брэндийг зах зээлд нэвтрүүлэхээр ажиллаж байсан билээ. 2022 оны зорилтын хүрээнд “Прайм пастри” ХХК байгуулан үйл ажиллагааг тусад нь гаргаж хүнсний аюулгүй байдлын стандартад нийцсэн олон улсын шинэ хэрэглээний соёлыг нэвтрүүлэхийн тулд ажилласан.

Бид 5 жилийн хугацаанд судалгаа туршилтын ажлыг шат дараатай хийж, техник технологи, бүтээгдэхүүний төрөл, амт чанар, хүнсний стандарт аюулгүй байдал, ажилчин гэсэн үндсэн хүчин зүйлүүдэд онцгойлон ач холбогдол өгч “Сэтгэл булаам амт” уриатай “DELICE PASTRY” брэндийн бүтээгдэхүүнээ хэрэглэгчдийн гарт хүргэж эхлээд байна.

2026 он хүртэл 5 жилийн хугацаанд үйлдвэрлэлийн хүчин чадал, борлуулалтын нэмэгдүүлэх үе шаттай стратеги төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэн ажиллаж байна. 2022 онд нийт 16 нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2800 гаруй цэгт түгээлт хийж байна.




НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ



2022 оны 5-р сард Итали, БНЧУ, Герман, БНХАУ, Голланд улсын давхраат болон хөөмөл төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт судалгааны ажлыг дуусгаж, “Delice pastry” гэх шинэ брэндийг зах зээлд нэвтрүүлж, албан ёсны нээлтийн арга хэмжээг амжилттай зохион байгуулж чадлаа.

ТҮМЭН НАСАН БРЭНД



“Талх Чихэр” ХК нь “Атар” брэнд, “Түмэн насан” брэнд, “Өв соёл” хэвийн боовыг үйлдвэрлэн худалдаанд гаргасан. 2022 онд “Өв соёл” хэвийн боовыг гол бүтээгдэхүүн болгон хэрэглэгчдэд өв уламжлалаа хадгалан үлдэх, өрх тусгаар залуу гэр бүл идээ засах ёс уламжлалыг уриалан маркетингийн идэвхжүүлэлтээ хийн ажилласан. Жил бүр уламжлал болгон “Атар” хэвийн боовны нэрэмжит улс, аймгийн цолтой 256 бөхийн барилдаан, хэвийн боовны үйлдвэрлэлийн нээлтийн эвент арга хэмжээг зохион байгуулж, хэрэглэгчдэд шууд хүрэх борлуулалтын сувгуудаар амжилттай хүргэж ажиллаа.

“ХОТОЛ” БРЭНД

“Хотол” бялууны үйлдвэр нь амтат бялууг баяр бүрийн гол амттан байлгах үүднээс тусгай загвар, чимэглэлтэйгээр үйлдвэрлэж байгаа. Бялуу гэдэг бүтээгдэхүүн өөрөө ямар ч онцлох баярыг илэрхийлэх онцгой бүтээгдэхүүн юм. Иймээс бид баяр бүрийг онцгой хэмээн үзэж, тухайн баярт зориулан онцгойлон чимэглэл хийж, маркетингийн идэвхжүүлэлтээр дамжуулан хэрэглээний соёлыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Монголд бялуу, бялуун төрлийн бүтээгдэхүүний эрэлт хурдацтай өсөн нэмэгдэж байна. Тийм ч учраас нарийн мэдрэмж, технологи ажиллагаа, эрүүл ахуйн өндөр хяналт шаардсан бялуу, бэйкери төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тал дээр онцгой ач холбогдол өгөн ажиллаж байна.

Бид түүхий эд болон бүтээгдэхүүний судалгаа, хөгжүүлэлтийн үндсэн дээр өнөөдөр 30 гаруй нэр төрлийн бялуу 80 гаруй төрлийн бэйкери бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.



“ТА ЧИ” БРЭНД

2010 онд нарийн боовны үйлдвэрийг БНЧУ, Голланд улсын “J4” компанийн UNILINE, UNIMAX иж бүрэн шугам шинэчлэн нарийн боовны зах зээлд “Та Чи” брэндийг нэвтрүүлж, зах зээлийн эзлэх хувиа өсгөж чадсан.

Дээрх шугамууд нь өдөрт 8 цагаар 10 жил ажиллах хүчин чадалтай. Гэвч дотоодын хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээ шаардлагаас үүдэн бид 24 цагийн турш тасралтгүй үйлдвэрлэл явуулсаар ирсэн. Гэтэл удаан хугацаанд ажилласан 2 шугамын ачаалал нэмэгдэж, элэгдэлтэй холбоотой гэмтэл их гарах болсон. Уг нөхцөл байдлаас шалтгаалан засварын урсгал зардал сүүлийн жилүүдэд огцом нэмэгдсэн, үйлдвэрлэл зогсох хүртэл нөхцөл байдал үүссэн, мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай байгаа зэрэг олон асуудал үүсээд байна. Энэ байдал удаан үргэлжилбэл бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, компанийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж, нарийн боовны үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн жигд, явуулахад бэрхшээл үүсгэх болсныг харгалзан, дээрх 2 шугамын үйл ажиллагааг зогсоон актлах нь зүйтэй гэж үзэж байна.

Бид зах зээлээ хадгалж үлдэхийн тулд цаашид хөрөнгө оруулалт хийх, менежментийн үйл ажиллагааг авч явах чадамжтай компанитай хамтран ажиллахаар төсөл, төлөвлөө боловсруулан ажиллаж байна.



“Талх Чихэр” ХК-ийн брэнд бүтээгдэхүүн бүр хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхолд нийцсэн байдаг. Тэр ч утгаараа бид хэрэглэгчийн сегмент бүрд тохирсон брэндийн идэвхжүүлэлтийн ажлыг сошиал маркетингийн суваг ашиглан хийж, бүтээгдэхүүнтэй холбоотой мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна.



**Хэзээ ч Хаана ч Өөрийнхөөрөө
 “ХААН” БРЭНД**

Онцгой бүхэн танд байгаа
 “ОНЦГОЙ” БРЭНД

Жинхэнэ багет
 “FRENCH BAGUETTE” БРЭНД



Байнгын сайжруулалт

Хэрэглэгчийн санал хүсэлт, гомдлыг түргэн шуурхай хугацаанд шийдвэрлэх нь тухайн байгууллагын алсын хараа, стратегийн хувьд томоохон байр суурь эзэлдэг. Иймээс бид байнгын сайжруулалтын ажлын хувьд хэрэглэгч, харилцагчаас санал гомдол хүлээн авдаг байсан 9830-9001 дугаарын үйл ажиллагааг сайжруулж, хэрэглэгчээс ирж буй дуудлага бүрийг алдахгүй хүлээн авч, шийдвэрлэх зорилгоор CallPro ХХК-тай хамтран 7288-8888 дугаарыг ХЭРЭГЛЭГЧИЙН УТАС болгон шилжүүллээ. Мөн хэрэглэгчийн гомдол, саналын тайланг гаргаж хийгдэх ажлуудыг төлөвлөн, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд бүтээгдэхүүнээс хамаарсан гомдол **3,6%**-иар буурч, хэрэглэгчийн сэтгэл ханамж өмнөх онтой харьцуулахад **1,0%**-иар дээшилсэн үзүүлэлтэй байна.



ISO 9001:2015 стандартын шинэчилсэн хувилбар руу шилжиж баталгаажуулахтай холбоотой ажил төлөвлөн хийж гүйцэтгэсэн. MNS ISO 17025:2018 стандартыг хими, микробиологийн лабораторийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн хүнсний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавин ажилладаг ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлэх ажлыг төлөвлөн, баталгаажуулах хүсэлтээ илгээгээд байна.

—ҮЙЛДВЭРЛЭЛ, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

ISO 9001:2015 МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО

“Талх Чихэр” ХК эрүүл, аюулгүй, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор олон улсын “Чанарын менежментийн тогтолцоо” ISO 9001:2015 стандартын давтан баталгаажуулалтад амжилттай орж, гэрчилгээгээ гардан авсан.



ISO 2022:2018 ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

ISO 22000:2018 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, хэрэглэгчийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтвортой хангаж, үйл ажиллагаандаа байнгын сайжруулалт хийж байна.

2022 оны 10 сард Олон улсын итгэмжлэгдсэн төлөөлөгч Австри улсын “TUV Austria” аудитын компаниар магадлан баталгаажуулалтыг амжилттай хийсэн.

ZERTIFIKAT | CERTIFICATE | CERTIFICADO | CERTIFIKAT | 証明書 | 證書 | 인증서



ГЭРЧИЛГЭЭ

TÜV
AUSTRIA

EN ISO 22000:2018
Менежментийн тогтолцоо

TÜV AUSTRIA -ийн журмын дагуу

ТАЛХ-ЧИХЭР ХК
18070, Ш/Х – 37, Монгол улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Энхтайваны өргөн чөлөө

Хүнсний аюулгүй байдлын Менежментийн тогтолцоог дээрх стандартын дагуу дараах үйл ажиллагаанд нэвтрүүлсэн тул гэрчилгээ олгов.

Талх, жигнэмэл болон чанамал гурилан бүтээгдэхүүн, жигнэмэг, өрмөнцөр, бялуун бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түгээлт

Гэрчилгээний бүртгэлийн дугаар № 20154193005363

Хүчинтэй хугацаа: 2024-08-19
Өмнөх гэрчилгээ: 2021-08-20

Гэрчилгээ олгогч байгууллага
at TÜV AUSTRIA CERT GMBH

Vienna, 2021-08-20

Тус баталгаажуулалтыг TÜV AUSTRIA CERT-ийн аудит гүйцэтгэх, баталгаажуулах журмын дагуу гүйцэтгэсэн бөгөөд цаашид тогтмол хяналтын аудитад хамрагдана.
TÜV AUSTRIA CERT GMBH Deutschstraße 10 A-1230 Wien www.tuv.at



Online Verification



www.tuv.austria.com

MNS ISO 17025:2018 ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОР

“Сорилт, шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих шаардлага MNS ISO 17025:2018” шинэчлэгдсэн стандартын шаардлага хэрэгжүүлэх ажлын хүрээнд төлөвлөгөөт ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2022 оны 8 давтан магадлан баталгаажуулалт үнэлгээ амжилттай хийсэн.



ХӨДӨЛМӨР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛТОО ISO 45001:2018 СТАНДАРТ

2022 оны 6 сараас эхлэн ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын менежментийн тогтолцоог нэвтрүүлэхээр ажиллаж байна.

ХЭМАБ-н тогтолцоог нэвтрүүлэх хөтөлбөрийг төлөвлөн үйл ажиллагаандаа аюул, эрсдэл, үйлдвэрийн хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг компанийн хэмжээнд хэрэгжүүлсэн.

2023 оны 05-р сард ХЭМАБ-н тогтолцооны үнэлгээ, баталгаажуулалтыг СХЗГ-р хийлгэхээр төлөвлөсөн.



100,8 ТЭР БУМ


НИЙТ БОРЛУУЛАЛТЫН
ОРЛОГО

5,8 ТЭР БУМ

УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН
ОРЛОГОД

— САНХҮҮГИЙН ТАЙЛАН

“Талх Чихэр” ХК нь 2022 онд **100,8** тэрбум төгрөгийн борлуулалт хийж, урьд оноос орлого **25** тэрбум төгрөгөөр буюу 33%-р өссөн байна. Улсад орлогын татвар 1,119,5 сая төгрөг төлсөн бөгөөд урьд оноос 473,7 сая төгрөгөөр давуулсан байна. Монгол улсын нэгдсэн төсвийн орлогод 5,8 тэр бумыг төвлөрүүлсэн.



Ажиллагсдын хөгжил, ажлын бүтээмжийг
нэмэгдүүлэх, менежментийн тогтолцоо
бүрдүүлэх, тогтвор суурьшилт, үр бүтээлтэй
ажиллагсдыг урамшуулах оновчтой, дүгнэхүйц,
ил тод системийг бий болгох.

—ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Ажиллах хүчний нөөц

Хүйс болон нас



519

Эмэгтэй



425

Эрэгтэй

Ажилтнуудын дундаж нас 65,6%



20-45 нас

Ажилчидын харьцаа

Нийт
ажилтан




944

Нэмэгдсэн
ажлын байр



58



210

Түгээлтийн
ажилтан



442

Үйлдвэрийн
ажилтан



291

Оффисийн
ажилтан

СУРГАЛТ, ХӨГЖҮҮЛЭЛТ

Ажилчдыг сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагааг дотоод нөөц бололцоогоор тогтмол хийж хэрэгжүүлсэн. Мөн олон жил ажилсан болон оны шилдэг ажилчдадаа үнэлэн гадаад туршлага судлуулах зорилгоор Турк улс уруу явуулсан. Нийт 11 чиглэлийн сургалтад 507 ажилчид хамрагдсан.

- Галын аюулгүй байдал
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай
- ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн стандарт нэвтрүүлэх
- ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо
- Гадаад мэргэжилтэн болон зөвлөх инженерийн технологи болон тоног төхөөрөмжийн сургалт
- Хувь хүний хөгжлийн сургалт
- Шинэ ажилтны танилцуулах сургалт
- Тусгай ур чадвар олгох сургалт



ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Ажилчдадаа тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэх үүднээс спортын тэмцээн, урлагийн наадам, аялал, шагнал урамшуулал зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.



УРАМШУУЛАЛ

Оффисын болон үйлдвэрийн дундаас дээш түвшний ажилтнуудад ажлын үнэмлэх, лого бүхий хувцас олгож эхэлсэн. Ажилчдад тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогын хүрээнд цалин, урамшуулал нэмэгдүүлсэн.

- Спортын шигшээ багийн тамирчдадаа ур чадварын нэмэгдэл
- Тогтвортой ажилласан жилийн нэмэгдэл
- Гүйцэтгэлийн үнэлгээгээр урамшуулал
- Хөдөлмөрийн аварга урамшуулал
- Түлхүүр ажилчдын урамшуулал



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Хэрэглэгчдийн эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөгүй, мөн хамтрагч байгууллага, ажиллагсдынхаа өмнө хүлээх хариуцлагаа үйл ажиллагаандаа тусган ажилдаг нийгмийн хариуцлагатай компани юм.

“NC CENTER” ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

СХД-ийн иргэд болон ажилтан, албан хаагчдадаа зориулан “Талх Чихэр” ХК-ийн эзэмшил болох **1550,6 м2** газрыг нийгмийн хариуцлагын хүрээнд NC CENTER үйлчилгээний төвд шилжүүлсэн. Уг төв нь СХД-ийн иргэдэд зайлшгүй шаардлагатай байсан эрүүл мэндэд чиглэсэн Фитнес клуб, Йоги, Спорт заал, Бэйкери шоп, Супер маркет зэрэг үйлчилгээ үзүүлэх цогцолбор юм. Ингэсээр хүүхэд залуучууд болон ажилчид чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломж бүрдэж байгаа юм. Мөн 3 талт LED дэлгэцээр нийгмийг уриалсан аян болон анхааруулах видеог СХД-ийн замын цагдаагийн алба, төрийн бусад байгууллагуудтай хамтран мэдээлэл хүргэх, сэрэмжлүүлэх зорилгоор байршуулан явуулдаг. NC CENTER үйлчилгээний төвд “Талх Чихэр” ХК үйлчилгээний зориулалт бүхий талбай эзэмшиж хэрэглэгчдэдээ улам ойртсоор байна.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Хэрэглэгчдийн эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөгүй, мөн хамтрагч байгууллага, ажиллагсдынхаа өмнө хүлээх хариуцлагаа үйл ажиллагаандаа тусган ажилдаг нийгмийн хариуцлагатай компани юм.

БААТРУУДААРАА БАХАРХЬЯ

"Талх Чихэр" ХК жил бүрийн сар шинийн баярын өмнө Хөдөлмөрийн баатруудаараа бахархан хүндэтгэл үзүүлж, алдаршуулдаг уламжлалтай. Уг уламжлалын дагуу малчны хот, хөнгөн үйлдвэрийн цех, уул уурхай, урлаг, спорт гээд бүхий л салбараас өөрийн ажил хөдөлмөр хичээл зүтгэлээ төр засаг, түмэн олноороо үнэлүүлж, төрийн их хайр хишгийг хүртсэн эрхмүүддээ хүндэтгэл үзүүлэх уг арга хэмжээг "БААТРУУДААРАА БАХАРХЬЯ" нэрийн дор 8 дахь жилдээ ийнхүү амжилттай зохион байгууллаа.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Хэрэглэгчдийн эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөгүй, мөн хамтрагч байгууллага, ажиллагсдынхаа өмнө хүлээх хариуцлагаа үйл ажиллагаандаа тусган ажилдаг нийгмийн хариуцлагатай компани юм.

АМТЛАГ АЯЛАЛ 2022

"Амтлаг аялал" нэрийн хүрээнд Улаанбаатар хотын 10 жилийн сургууль, хамтран ажиллагч байгууллагын 2000 гаруй хүүхэд багачуудад үйлдвэрийнхээ үйл ажиллагааг танилцуулсан байна. Аялалд оролцсон хүүхэд бүртээ бид #Амтлаг брэндийнхээ бүтээгдэхүүний дээжийг бэлэглэсэн билээ.

"Талх Чихэр" ХК, Good Neighbors Mongolia ОУТББ-тай хамтран 18 нас хүрч, ирээдүйн амьдралдаа анхны алхмаа хийж байгаа хүүхдүүддээ зориулан мэргэжил сонголтод нөлөөлөх ажлын хүрээнд өөрсдийн үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцуулсан.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Хэрэглэгчдийн эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөгүй, мөн хамтрагч байгууллага, ажиллагсдынхаа өмнө хүлээх хариуцлагаа үйл ажиллагаандаа тусган ажилдаг нийгмийн хариуцлагатай компани юм.

АМТЛАГ БАГ

2022 онд “Талх Чихэр” ХК нийгмийн хариуцлагын хүрээнд хүүхэд залууст зориулсан “Амтлаг” брэндээр “Туулын Том Тулнууд” хөл бөмбөгийн багийг ивээн тэтгэж, иж бүрэн өмсгөл бэлэглэсэн. Мөн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, салбартаа тэргүүлж байгаа залуу багийн үйл ажиллагааг дэмжин 11 сард “Талх Чихэр” ХК-ийн СІТҮ спорт зааланд нөхөрсөг тоглолт хийн, нэг өдрийг дурсамж дүүрэн өнгөрүүлсэн билээ.



Амжилт 2022 он

Топ 100



Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжил цэцэглэлтэд оруулсан бидний хувь нэмрийг үнэлэн Засгийн газар, МҮХАҮТ хамтран “ТОП-100 аж ахуйн нэгж”-ээр шалгаруулсан.

Ард түмний хүнс



"Намрын ногоон өдрүүд - Үндэсний үйлдвэрлэл-2022" арга хэмжээний үеэр "Талх Чихэр" ХК-ийн Онцгой брэндийн "Олон үртэй ургац" талх "АРД ТҮМНИЙ ХҮНС"-ээр шалгарлаа

Шинэ шилдэг



"Намрын ногоон өдрүүд - Үндэсний үйлдвэрлэл-2022" арга хэмжээний үеэр "Талх Чихэр" ХК-ийн Хаан брэндийн "Чиабатта" талх "ШИЛДЭГ ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН"-ээр шалгарлаа

“Талх Чихэр” ХК-ийн ТУЗ 2022 оны үйл ажиллагаатай танилцаж, зорилго, зорилтод нийцсэн гүйцэтгэлийг үнэлэн хангалттай хэмээн дүгнэлээ.



ТАЛХ ЧИХЭР ХК

1984

2023 оны Бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө

- ▶ “ISO 22000:2018” ХАБМТ-ны стандарт дээр тулгуурлан үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулах зорилгоор “FSSC 22000” – хүнсний аюулгүй байдлын схем, хүнсний чанар, хүнсний хамгаалалт, хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлэх ажиллагааг хамарсан иж бүрэн менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлж, баталгаажуулалт үнэлгээг хийлгэнэ.
- ▶ “MNS ISO 45001:2018” ХЭМАБМТ-ны стандартын үнэлгээ, баталгаажуулалтыг хийлгэж, үйл ажиллагаандаа нутагшуулан, сургалт хөгжүүлэлтийг тогтмолжуулж, гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт /KPI/ -р үнэлэх системийг сайжруулна.
- ▶ Бялуун төрлийн бүтээгдэхүүний шинэ тренд бий болгож, Хэвтэй талхны шугамыг бүрэн автоматжуулан хүчин чадал болон нэр төрлийг 30-иас 40%-иар, Давхраат болон Хөөмөл бүтээгдэхүүний нэр төрлийг 50%-иар, Монголын үндэсний тавгийн идээний боовны нэр төрлийг 10%-иар тус тус нэмэгдүүлнэ.
- ▶ Техник, тоног төхөөрөмжийн засварын нөөц бүрдүүлж, мэдээллийн сан үүсгэх, уламжлалт чаналгын бүтээгдэхүүн үндсэн дамжлага / хивлэгээ, бэмбий/-г механикжуулж, гар ажиллагааг 20%-иар багасгах, “Багет” ,” Чиабатта” талхны шугамыг бүрэн автоматжуулсан хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- ▶ Сонирхогч талууд болон хэрэглэгчийн сэтгэл хангамжийн хэрэгцээ, шаардлагыг судлан, сэтгэл ханамжийн түвшин 8%-иар дээшлүүлж, Зах зээлд шинээр нийлүүлсэн бүтээгдэхүүний борлуулалтыг 10%-иар өсгөнө.
- ▶ Нарийн боовны үйлдвэрийн UNILINE, UNIMAX шугамыг актлан, зах зээлээ хадгалж үлдэхийн тулд цаашид хөрөнгө оруулалт хийх, менежментийн үйл ажиллагааг авч явах чадамжтай компанитай хамтран ажиллана.



АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА